

Баян-Олгий аймгийн нийт нутгийн далан хувь нь цастай байна. Дэлvн сумын нутаг цасгvй, Алтай, Буянт, Олгий зэрэг сумдын нутагт энэ сарын 17, 20, 21-ний одрvндэд нэмж цас орсон бoгoод энэ долоо хоногт уулархаг нутгуудаар дахин цас орох юм байна.

Цэнгэл, Улаанхус, Баяннуур сумдын нутгаар зузаан цастай, 28 хэм хvрч хvйтний эрч чангарч байгаа ч байдал гамшгийн хэмжээнд хараахан хvрээгvй, гэхдээ сонор сэрэмжтэй, бэлтгэлтэй байхыг аймгийн засаг даргаас онцгой байдлын алба, холбогдох бусад байгууллагынханд анхаарууллаа. Энэ долоо хоногийн сvвлчээр хvйтний эрч намдах толовтэй болохыг ус цаг уурынхан мэдээлээд байна.



Харин Олгий сумын нэгдсэн халаалтын хэрэглэгчид дулааны шугамын вйл ажиллагаанд сэтгэл дундуурхан байна. Нутаг нь цасан бvрхvлтэй байгаа Алтай суманд шvлхий овчинтэй холбоотой хорио цээр цуцлагдсан ч уг сумаас гадагшаа мал болон мал аж ахуйн бvтээгдэхvн гаргахыг хязгаарласаар байна.Â